

Санал асуулгын нэгдсэн дүн

Хавсралт

Санал асуулгын нэгдсэн дүн

2010.03.21

Алтай хот

Монгол улсын Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд, төсөвт байгууллагууд үйл ажиллагаа, хууль сурталчилах, иргэдийн санал бодлыг нь сонсох, санал авах иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт болон агентлагын ажлын үр дүнгийн талаар 6 удаа нээлтэй хаалганы өдөрлөгийг аймгийн төвд зохион байгуулж иргэдээс санал авах хайрцаг, нээлттэй утас, mail хаягаар саналуудыг тус тус авлаа.

Уулзалтын үед нийт 1641 санал хүсэлтийг хүлээн авсанаас 1183 санал хүсэлтийг нь газар дээр нь шийдвэрлэлээ.

Энэ үеэр иргэдээс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 55.5 хувь нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай, 33.9% нь дунд зэрэг, агентлаг албадын ажлыг 24.1 хувь нь хангалттай, 42.7 хувь нь дунд зэрэг гэж дүгнэсэн байна.

Засгийн газрын тогтоолын дагуу “Нэг цонхны үйлчилгээ”-ний нээлтийн ажиллагааг зохион байгуулж төрийн байгууллагуудас иргэдэд үзүүлж байгаа төрөл бүрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлж, олон үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүйгээр нэг дороос хүргэх болсонд иргэд талархаж байлаа.

Нээлттэй хаалганы өдрөөр иргэдэд хуулийн зөвлөгөө өгөх, иргэдийн бүртгүүлж баталгаажуулаагүй нэгж талбар газруудыг бүртгэлжүүлэн гэрчилгээжүүлэх, газрын мэдээллийн сангаар иргэдэд үнэ төлбөргүй үйлчилэх, албан бусаар хөдөлмөр эрхэлдэг иргэдийг үнэмлэхжүүлэх, хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр жижиг зээл авч үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэнд жижиг зээл олгох журмын дагуу хүсэлтээ гаргасан иргэдийг арилжааны банкуудаар дамжуулан судалж асуудлыг нь шийдвэрлэх, хөдөлмөр эрхэлж ажлын байр бий болгон өөрийн өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гутлын иж бүрэн тоног төхөөрөмж олгох, хортой болон хугацаа хэтэрсэн чанаргүй бараа бүтээгдэхүүнийг сурталчилах зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр иргэдээс ирүүлсэн тухай үед нь шийдвэрлэх боломжгүй 458 санал хүсэлтийн хариуг өргөдөл гомдол шийдвэрлэх хуулийн дагуу хуулийн хугацаанд нь шийдвэрлэж иргэдэд хариу мэдэгдэхийг сум, агентлаг, албадын дарга нарт үүрэг болголоо.

Ахмадын хороотой аймгийн ЗДТГ-ын дарга хамтран ажиллах 10 заалт бүхий гэрээ байгуулж ажиллалаа.

Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22-р тогтоолоор “Иргэний нийгмийн өдөр-1 дүгээр сарын 31”-ийг тэмдэглэн өнгөрүүллээ.